



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 656

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч С.Ганбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-

006021371

2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч С.Ганбат Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч С.Ганбатын мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч С.Ганбатад

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2024 оны Баян-Агт сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд
Бие даан нэр дэвшигч Самдангийн Ганбатын мөрийн хөтөлбөр

1. Шарга нуурын усны түвшинг нэмэгдүүлэх талаар мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэхийг дэмжин ажиллах,
2. Хагийн нуурыг сэргээх, усны түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр гүний усны хайгуул хийж сэргээх судалгаа хийлгэх, төсөв гаргуулах, хэрэгжүүлэх чиглэлийг баримтлан ажиллах,
3. Сумын төвийн үерийн ус зайлуулах далан, суваг шуудууны судалгаа хийлгэхийг дэмжин ажиллах,
4. Хануйн гүүр буюу Хөтөл уснаас сумын төв хүртэлх замыг хайрган хучилттай болгох судалгаа, зураг төсөв хийлгэхийг чиглэлийг баримтлан ажиллах,
5. Сумын хилийн зааг дээрх Хөтөл усны хэсэгт хайрган хучилттай зам хийлгэх судалгааны ажлыг дэмжин ажиллах,
6. Хөрсний элэгдэл, эвдрэлийг сааруулах бодлого, санаачилга баримтлан ажиллах,

С.Ганбат
утас: 95298811